

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### “ШИЙТГЭЛИЙН ХУУДАСНЫ МАЯГТ 1, МАЯГТ-2”

“Шийтгэлийн хуудасны маягт 1, маягт-2”-нь үндсэн фон хүрээ хээгээр адил бөгөөд хэвлэлтийн өнгө, үндсэн бичвэр мэдээллээрээ ялгаатай.

**Хэмжээ:** Шийтгэлийн хуудас маягтууд нь А4 /210х297мм/ хэмжээтэй.

**Цаас:**

-**Шийтгэлийн хуудас маягт 1** нь улбар шар өнгийн хэвлэлттэй бөгөөд 3 өнгийн хорын цаастай. СВ-52 гр цагаан, СВF-50 гр ягаан, СВF-50 гр цэнхэр өнгийн цаас байна.

-**Шийтгэлийн хуудас маягт 2** нь цайвар цэнхэр өнгийн хэвлэлттэй бөгөөд мөн 3 өнгийн хорын цаастай. СВ-52 гр цагаан, СВF-50 гр ягаан, СВF-50 гр цэнхэр өнгийн цаас байна.

Черниль, балаар бичилт хийхэд тохиромжтой, хурдан хатдаг, тамга тэмдгийн дардас тогтвортой байх бичгийн зориулалттай цаасан дээр хэвлэгдсэн болно.

Шийтгэлийн хуудасны маягт-1, маягт-2 ын өнгийн хорын цаас нь тод гаргацтай байх шаардлагатай.